

# ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт  
Нүүрс  
Төмрийн хүдэр  
Зэс  
Газрын тос



## АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ 2022 оны 4-р сарын 11

**Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал**

Өнгөрсөн 7 хоногт алтны ханш 1,925 ам.долларт нээгдэн 1,947.68 ам.долларт хүрч өссөнөөр 1.18 хувийн уналт үзүүлсэн байна.

- ОХУ, Украйны тодорхойгүй нөхцөл байдал, инфляц, COVID-19 цар тахлын тархалт алтын ханшийг дэмжиж байна. Гэвч Холбооны Нөөцийн Сангийн инфляцийн эсрэг хэрэгжүүлж буй бодлого, бондын өгөөжийн өсөлт, цар тахлын хязгаарлалтыг сулруулж байгаа зэрэг нь алтны ханшийг огцом өсгөхгүй байх шалтгаан болж байна.

- АНУ-ын ам.долларын ханш 2 жилийн дээд цэгтээ хүрч, 3 сарын эхэн үеэс хойш долоо хоног бүр өсөлттэй байгаа нь ХНС-ийн зүгээс инфляцийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг хурдацтай нэмэгдүүлэхийг уриалж байгаатай холбоотой. Долларын ханш чангарах нь бусад валют эзэмшигчид алтыг сонирхох боломж олгохгүй байна.

- ХНС-ийн 2022.3.5-16-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс харахад ирэх саруудад бодлогын хүүгээ 50 нэгжээр өсгөхөөр бэлтгэж байна.

- АНУ-ын 10 жилийн хугацаатай Төрийн сангийн жишиг өгөөж сүүлийн гурван жилийн дээд түвшинд хүрлээ.

- ОХУ-ын Төв банк "Зах зээлийн нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөгдсөн" учир 4 сарын 8-аас эхлэн арилжааны банкнуудаас алт тохиролцсон үнээр худалдаж авна гэж мэдэгдлээ.

Golomt\_Capital published on TradingView.com, Apr 11, 2022 10:25 UTC+8

Gold Spot / U.S. Dollar, 4h, OANDA O1945.380 H1947.850 L1941.380 C1941.510 -3.870 (-0.20%)



TradingView

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 4 сарын 11

**Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:**

- Дэлхийн газрын тос хэрэглэгч орнууд стратегийн нөөцөөсөө түүхий нефт гаргахаа зарласан ба БНХАУ хөл хориогоо үргэлжлүүлснээр нефтийн үнэ даваа гарагт Азийн зах зээл дээр хоёр ам.доллараар буурчээ.

- АНУ болон ОУЭА-ийн орнуудын газрын тосны нөөцийг гаргах хамтын хүчин чармайлтын үр дүнд газрын тосны үнэ буурч байна. Мөн дэлхийн хамгийн том газрын тос импортлогч орон болох БНХАУ-ын 26 сая хүн амтай Шанхай хотод хөл хорио тогтоосон, Шэньян, Шанхай зэрэг үйлдвэрлэлийн төвүүд үйлдвэрлэлээ зогсоосны улмаас эрэлт буурч байна.

- Олон улсын эрчим хүчний агентлаг (ОУЭА)-ийн гишүүн орнууд ирэх 6 сарын хугацаанд 60 сая баррель нефть зах зээлд нийлүүлэх гэж байгаа нь Орос Украины дайнаас үүдсэн түүхий нефтийн хомсдолыг нөхөх зорилготой юм.

Гэвч энэ нь ОХУ-аас үүдэлтэй нефтийн хомсдолыг бүрэн нөхөж чадах эсэх нь тодорхойгүй байна. Учир нь Энэтхэг хямд үнээр газрын тос авч байгаа тул импортоо нэмэгдүүлж байна.

- Даваа гарагт Ерөнхийлөгч Жо Байден Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модитой цахимаар уулзана гэж Цагаан ордон мэдэгдлээ. АНУ Энэтхэгээс Оросын эрчим хүчний импортыг нэмэгдүүлэхийг хүсэхгүй байгаагаа тодорхой илэрхийлсэн.

- 4 сарын 1-6-нд ОХУ-ын газрын тос, хийн конденсат олборлолт 3 сарын дундаж 11.01 сая баррелиас 10.52 сая баррель болж буурчээ.

Гэсэн ч ОПЕК+ газрын тос экспортлогч орнууд нийлүүлэлтээ нэмэгдүүлэх ажлын хүрээнд олборлолтын зорилтоо нэмэгдүүлэх хандлагатай байгаа юм.

- Өнгөрөгч долоо хоногт АНУ-д эрчим хүчний компаниуд гурван долоо хоног дараалан газрын тос, байгалийн хийн цооногуудаа нэмлээ.

Golomt Capital published on TradingView.com, Apr 11, 2022 10:25 UTC+8  
CDS on WTI Crude Oil, 4h, TYC 08:07 HK\$11 CNY19 CNY32 -0.78 (-0.79%)



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.